



## ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН “ОЮУНЫ УУРХАЙ” СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 05 сарын 08 өдөр

Дугаар 6/32

Бор-Өндөр сум

Г Т.Түвшинжаргалын албан тушаалыг өөрчлөн,  
түр томилох тухай

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, 33.3.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 50 дугаар зүйлийн 50.1.2, 78 дугаар зүйлийн 78.1.1, 101 дүгээр зүйлийн 101.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.3 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, 2024 оны 238 дугаар тогтоолын 11 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Үйлчлэгч Төмөрхуягийн Түвшинжаргалыг 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн няравын албан тушаалд туршилтын хугацаагаар түр томилсугай.

2.Т.Түвшинжаргалын албан тушаалын үндсэн цалинг ТҮ-4 зэрэглэл 1,105,000 (нэг сая нэг зуун таван мянга) төгрөгөөр тогтоож, хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн нэмэгдэл хөлс олгохыг нягтлан бодогч (Б.Анхчимэг)-д зөвшөөрсүгэй.

3.Хууль тогтоомж, дүрэм журмыг чанд мөрдөн ажиллахыг нярав (Т.Түвшинжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙН  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ч.АМАРЖАРГАЛ

